

ЖИЛИЙН ТАЙЛАН 2024

Улаанбаатар хот

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАРДААТГАЛ



Мэндчилгээ

Сайн байцгаана уу?

Өнгөрсөн 2024 онд манай компани үүсэн байгуулагдсаны 10 жилийн ой тохиолоо. Бид цорын ганц үндэсний давхар даатгагчийн хувьд Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмрээ оруулсан, өнгөрөгч онд хүрсэн үр дүнгээ бататгасан, харилцагч байгууллагууд, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг бэхжүүлсэн, олон улсын хамтын ажиллагаагаа өргөтгөсөн нэгэн жилийг амжилт бүтээлээр дүүрэн үдлээ.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч AM Best агентлаг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр "Үндэсний давхар даатгал" ХК-ийн ерөнхий санхүүгийн чадавхыг B, урт хугацааны зээлжих зэрэглэлийг BB+, цаашдын төлөвийг

“Тогтвортой” гэж үнэллээ. “Үндэсний давхар даатгал” ХК-ийг санхүүгийн чадавхын хувьд “very strong” буюу “маш өндөр”, үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдэлийн удирдлагыг “хангалттай” хэрэгжүүлэн ажилладаг гэж үзжээ. Энэхүү үнэлгээнд компанийн санхүүгийн чадавх, үйл ажиллагааны гүйцэтгэл, бизнесийн профайл, эрсдэлийн зохистой менежмент (ERM) зэргийг тусгасан болно.

2024 онд малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрт 22 мянга гаруй малчин өрхөд 16.8 тэрбум төгрөгийг бүрэн олгож, Монгол Улсын даатгалын зах зээлийн түүхэн дэх хамгийн өндөр дүнтэй гамшгийн эрсдлийн хохирлыг нөхөн төлсөн ч AM Best агентлагийн хөрөнгийн зохистой харьцааг тооцох аргачлалын дагуу компанийн эрсдэлд суурилсан хөрөнгийн хэмжээг хангалттай түвшинд хадгалж, үүний үр дүнд балансын чадавх маш өндөр гэж дүгнэсэн.

Уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдлын нөлөөгөөр эрсдэлийн цар хүрээ, хэмжээ улам бүр өргөжиж, нийгэмд шинэ сорилтууд тулгарсаар байна. Өсөн нэмэгдэж буй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг шилжүүлэх давхар даатгалын оролцоо чухлаар тавигдах болсон. Ийм нөхцөлд бид үйл ажиллагааны цар хүрээгээ эрчимтэй өсгөн, хөрөнгө санхүүгийн чадавхаа улам бэхжүүлж, чадварлаг хүний нөөц, удирдлагын арга барилаар эрсдэл даах чадамжаа тасралтгүй сайжруулж ажиллалаа.

Шинэ технологи, ноу-хау нэвтрүүлэх, хүний нөөцийн чадавхаа улам бэхжүүлж санхүүгийн тогтвортой байдлаа ханган ажиллана гэдэгтээ итгэл дүүрэн байна.

“Үндэсний давхар даатгал” ХК-ийн нэрийн өмнөөс эрхэм хамтран ажиллагч түнш байгууллагууд, үйлчлүүлэгчдэдээ чин сэтгэлийн халуун талархал илэрхийлье!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
БАТМӨНХИЙН ЖАВХЛАНТ

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



"Үндэсний давхар даатгал" ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани юм.

Бид олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч AM Best агентлагаас хоёр дахь жилдээ ерөнхий санхүүгийн чадавхын хувьд В, урт хугацааны зээлжих зэрэглэлийн хувьд ВВ+, цаашдын төлөвөө "Тогтвортой" гэсэн үнэлгээ авч, компанийн хөрөнгө, үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн болон чанарын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагаандаа ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА:

Бид

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн, ашигт ажиллагааг дээдлэгч,
Төв Азийн тэргүүлэх давхар даатгагчдын нэг,
Мэргэшлийн дээд түвшний стандартыг тогтоогч,
Монгол Улсын давхар даатгалын жишиг компани,
Мэргэжлийн хөрөнгө оруулагч болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, үндэсний давхар даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.



ҮНЭТ ЗҮЙЛС:

"Үндэсний давхар даатгал" ХК-ийн алсын хараа, эрхэм зорилгод тусгасан зорилго, чиглэл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах үнэт зүйлсийг мөрдлөг болгон ажиллана.

МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХ: Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин

МАНЛАЙЛАЛ: Цаашдын зорилго, зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэн нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.

ХАМТЫН ЗҮТГЭЛ: Бусадтай хүндлэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.

ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ: Монгол Улсын хууль тогтоомжийг чандлан мөрдөж, "Үндэсний давхар даатгал" ХК-ийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.

ИЛ ТОД ХАРИЛЦАА ХОЛБОО: Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.

КОМПАНИЙН БҮТЭЦ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУДЫН ХЭРЭГЖИЛТ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн тухай хуульд заасны дагуу "Үндэсний давхар даатгал" ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчид (ХЭ)-ийн хурал байна. ХЭ-ийн хурлын бүрэн эрхийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Сангийн сайд хэрэгжүүлдэг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн тухай хуулийн 75.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2-т заасны дагуу ХЭ-ийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) юм. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд зааснаар ТУЗ 9 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байдаг. ТУЗ бүрэн эрхээ Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2 болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэн ажилладаг.

ТУЗ нь үйл ажиллагаагаа байнгын, тогтмол, мэргэшсэн байдлаар зохион байгуулах зорилгоор дэргэдээ "Аудитын", "Цалин, урамшууллын", "Нэр дэвшүүлэх", "Эрсдэлийн" гэсэн хороодыг байгуулсан.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг.

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулдаг.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор "Компанийн засаглалын кодекс" шинэчлэн батлагдсантай холбогдуулан шаардлагатай дүрэм, журам, бодлогын баримт бичгийг өөрийн компанийн онцлогт нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулж, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаар батлуулсан. Үүнд:

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам
3. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх журам
5. Дотоод аудитын журам
6. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам
7. Комплаенсын хяналтын журам
8. Мэдээллийн ил тод байдлын журам
9. Ажилтны ёс зүйн дүрэм
10. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам
11. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг
12. Эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх аргачлал
13. Залгамж халааны бодлогын баримт бичиг
14. Ногдол ашигтай холбогдох үйл ажиллагааг зохицуулах журам
15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах журам
16. Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг
17. Ажилтнуудаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам
18. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг
19. Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр

Эдгээр дүрэм, журам, бодлогын баримт бичиг болон "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

"ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ" ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ (2024 оны 4 дүгээр улирлын байдлаар)					
	Компанийн засаглалын кодексын зарчмууд	Хэрэгжилт	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	2	3	4	5	6
1	НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна	Хэрэгжүүлж ажилласан	12	11	91.7%
2	ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ	Хэрэгжүүлж ажилласан	10	10	100%
3	ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана	Хэрэгжүүлж ажилласан	6	6	100%
4	ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана	Хэрэгжүүлж ажилласан	6	6	100%
5	ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина	Хэрэгжүүлж ажилласан	8	7	87.5%
6	ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна	Хэрэгжүүлж ажилласан	6	6	100%
7	ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ	Хэрэгжүүлж ажилласан	8	8	100%
8	НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно	Хэрэгжүүлж ажилласан	6	6	100%
9	ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана	Хэрэгжүүлж ажилласан	10	10	100%
	Нэгдсэн дүн		72	70	97.2%

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

Монгол Улсад улаан буудайн индексжүүлсэн даатгалыг туршилтын байдлаар анх удаа нэвтрүүлэв.

Гэнэтийн осол, хөрөнгө, эрчимжүүлсэн мал аж ахуй, ачаа тээвэр, хариуцлага, санхүүгийн даатгалд давхар даатгалын үйлчилгээ үзүүлсэн ба нэмэлтээр агаарын хөлгийн их бие, барилга угсралт, авто тээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрүүдээр давхар даатгалын үйлчилгээ үзүүлэв.

Улаан буудайн индексжүүлсэн даатгалыг орчин үеийн дэвшилтэт технологи дээр үндэслэн боловсруулж, орон даяар амжилттай нэвтрүүлэв.

1. Монгол Улсад даатгагчийн баталгааны тогтолцоог нэвтрүүлэхээр ажиллаж эхлэв.
2. Сөүл баталгааны даатгал компанитай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.

1. "Үндэсний давхар даатгал" ХК үүсэн байгуулагдсаны 10 жилийн ой тохиов.
2. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Эй Эм Бэст агентлагаас "Үндэсний давхар даатгал" ХК-ийн ерөнхий санхүүгийн чадавхыг В, урт хугацааны зээлжих зэрэглэлийг ВВ+, цаашдын төлөвийг "Тогтвортой" гэж дахин үнэллээ.
3. Давхар даатгалын үйлчилгээг олон улсад экспортолж эхлэв.

Үүсэн байгуулагдав.

2014
ОН

2016
ОН

Олон улсад экспортын зээл, хөрөнгө оруулалтын даатгалын салбарт тэргүүлэгч Бернийн холбооны гишүүн байгууллагаар элсэв.

2017
ОН

2018
ОН

Давхар даатгалын трити гэрээ олон улсын нөхцөлөөр дотооддоо байгуулав. Мөн Азийн давхар даатгалын холбоонд элсэв.

2019
ОН

2020
ОН

Азийн батлан даалт, зээлийн даатгалын холбоо /Asian guarantee, credit insurance association/-той хамтын ажиллагаа тогтоож, гишүүн байгууллагаар элсэв. Монгол Улсад анх удаа экспортын зээлийн даатгалыг нэвтрүүлэв.

2021
ОН

2022
ОН

2023
ОН

2024
ОН


1. Компанийн үйл ажиллагаанд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэв.
2. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Эй Эм Бэст агентлагаас "Үндэсний давхар даатгал" ХК-ийн ерөнхий санхүүгийн чадавхыг В, урт хугацааны зээлжих зэрэглэлийг ВВ+, цаашдын төлөвийг "Тогтвортой" гэж үнэллээ.

■ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Тайлант онд компанийн хөрөнгө 62 тэрбум 345 сая төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын нийт хөрөнгийн 9,4 хувийг эзэлж байна.

Даатгалын хураамж өнгөрсөн жилээс 14 хувь буюу 969 сая төгрөгөөр өсч, 7 тэрбум 698 сая төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлснээр даатгалын зах зээл дэх нийт давхар даатгалын хураамжийн 4,7 хувийг бүрдүүллээ.


НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/




НИЙТ ОРЛОГО БА ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/



ДААТГАЛЫН ХУРААМЖ /тэрбум төгрөг/



НӨӨЦ САН /тэрбум төгрөг/




2024 ОНЫ АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН


“Үндэсний давхар даатгал” ХК нь 2024 онд дотоодын даатгалын компаниудад давхар даатгалын үйлчилгээ үзүүлэн трити, факультатив, фронтинг давхар даатгалын гэрээ байгуулж, нийт 7 тэрбум 697 сая төгрөгийн хураамж төвлөрүүллээ. Компанийн 2023 оны борлуулалтын үр дүнтэй харьцуулахад агаарын хөлөг, хариуцлагын даатгал, хөрөнгийн даатгалд өсөлттэй ажиллаж, хураамжийн орлого 14,4 хувиар нэмэгдсэн байна.

сая.төг	Хураамжийн орлого
Даатгалын хэлбэр	2024 он
Мал амьтдын даатгал (МИД)	1,404.60
Хөрөнгө	2,595.90
Тээврийн хэрэгсэл	1,676.50
Агаарын хөлгийн даатгал	131.5
Хариуцлага	1044.1
Барилга угсралт	273.2
Бусад	571.9
Нийт	7,697.70

ХУРААМЖИЙН ОРЛОГО



ХУРААМЖИЙН ОРЛОГЫН ХАРЬЦАА (ДААТГАЛЫН ҮНДСЭН ХЭЛБЭРҮҮДЭЭР 2023-2024 ОН)




	2023 он	2024 он
Мал амьтдын даатгал	1,691,21	1,404,60
Хөрөнгө	2,130,78	2,595,90
Тээврийн хэрэгсэл	1,142,28	1,676,50
Агаарын хөлгийн даатгал	102,6	131,5
Хариуцлага	922,0	1044,1
Барилга угсралт	329,34	273,2
Бусад	410,4	571,9

Давхар даатгалын хамгаалалт
Бүтээгдэхүүн үйлчилгээ

- Малын индексжүүлсэн даатгал;
- Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал;
- Эрүүл мэндийн даатгал;
- Хүнд машин механизмын даатгал;
- Хөрөнгийн даатгал;
- Хариуцлагын даатгал;
- Гэнэтийн ослын даатгал;
- Ачаа тээврийн даатгал;
- Барилга угсралтын даатгал (CAR/EAR);
- Агаарын хөлгийн даатгал;
- Агаарын хөлгийн хариуцлагын даатгал;
- Тээврийн хэрэгслийн даатгал;
- Хүнд өвчний даатгал
- Санхүүгийн даатгал
- Баталгааны даатгал
- Амьдралын даатгал

Хураамжийн орлогын багцын 87 хувийг
4 бүтээгдэхүүн эзэлж байна.



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН 2024 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН

МИД-ын 2024 оны борлуулалтыг 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал оролцогч Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, МИГ даатгал ХХК, Монгол даатгал ХК, Мөнх даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Хаан даатгал ХХК зэрэг 7 компани болон зуучлагч ХААН банк, Төрийн банктai хамтран зохион байгуулсан. Дээрх хугацаанд нийт 21,425 малчин өрхийн, 106 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 4,03 сая толгой малыг даатгалд хамруулсан.

Тайлант 2024 оны жилийн эцсээр Монгол Улсын хэмжээнд 195,746 малчин өрх, 57.6 сая толгой мал байгаагаас малчин өрхийн 11.0%, малын 8.0% нь МИД-д хамрагдсан байна.

МИД-ын бүтээгдэхүүнээр 3 тэрбум 728 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн байна. Үүнээс давхар даатгалын хураамжид 1 тэрбум 404 сая төгрөг компанид төвлөрүүлсэн.

Тайлант он	2021	2022	2023	2024
Даатгалын нийт хураамж	3,922	3,912	4,965	3,728
Даатгуулсан малчин өрх	34,709	27,456	35,703	21,425
Давхар даатгалын хураамж	1,319	1,296	1,688	1,404

МИД хэрэгжсэн 18 жилийн хугацаанд давхардсан тоогоор 350 мянган малчин өрхийн 73.2 сая толгой малыг даатгалд хамруулж, 37 тэрбум 401 сая төгрөгийн хураамжийн орлого

төвлөрүүлжээ. Эдгээрээс 81.9 мянган малчин өрх нийт 29.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү даатгалын ач тусыг малчид бодитоор хүртээд байна.




МИД-ЫН НӨХӨН ТӨЛБӨР


Үндэсний статистикийн хорооны хагас жилийн мал тооллогын үр дүнд тооцоолон МИД-д 2023 онд даатгуулсан 35,703 малчин өрхийн Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон аймгийн нийт 218 сум болон Улаанбаатар хотын 4 дүүргийн 22,034 малчин өрхөд нийт 16,817,662,257.18 төгрөгийн нөхөн төлбөрийг 2024 оны 4-р улиралд олгосон. Нөхөн төлбөр авсан малчин өрх нийт даатгалд хамрагдсан малчин өрхийн 62.0 хувийг эзэлж байна.

Сүхбаатар аймгийн 2,382 даатгуулагчдад 4,117.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон нь хамгийн өндөр үзүүлэлт байв. Мөн Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын малчин 6 сая төгрөгийн хураамж төлж, 650 малаа даатгуулснаар хамгийн өндөр нөхөн төлбөр болох 83.0 сая төгрөг авсан.

ДААТГАЛД ХАМРАГДСАН СҮРГИЙН БҮТЭЦ



МИД-ЫН ХУРААМЖ БА НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ



Нийт хураамж: 4,965.5
Нийт нөхөн төлбөр: 16,817.7

■ ГАДААД, ДОТООД ТҮНШЛЭЛ



Компанийн үйл ажиллагааг тэлэх, борлуулалтын сувгийг өргөжүүлэх, сайжруулах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлуудыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Олон улсын хамтын ажиллагаа:





Дотоодын хамтын ажиллагаа:



САНГИЙН ЯАМ



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР



МОНГОЛЫН ДААТГАЛЫН ХОЛБОО
INSURANCE ASSOCIATION OF MONGOLIA



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанийн эрсдэлийн засаглал дараах зүйлсээс бүрддэг. Үүнд:

- Хамгаалалтын гурван шугам
- Засаглалын баримт бичгүүд
- Засаглалын хороод



Компани нь “Хамгаалалтын гурван шугам”-ын зарчим бүхий эрсдэлийн засаглалыг хэрэгжүүлдэг. Энэ нь Компанийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулдаг.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь байгууллагад тулгарч болзошгүй төрөл бүрийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах, хянах зэрэг үйл ажиллагааны шат дарааллаас бүрддэг бөгөөд уг тогтолцоог хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бодлого, журам, арга аргачлалуудыг боловсруулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Даатгалын үйл ажиллагааны голлох үзүүлэлт болох даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж буй эсэхийг даатгагчийн хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа болон даатгагчийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцааг тооцох замаар тодорхойлдог. Компанийн хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа 100 хувиас их буюу нэгдүгээр түвшинд, зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа 0-ээс 10 хувь хүртэл буюу нэгдүгээр түвшинд байгаа тул компанийн төлбөрийн чадвар сайн буюу нэгдүгээр түвшинд байна.

Харьцаа үзүүлэлтүүд	2021 он	2022 он	2023 он	2024 он
Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа (Шалгуур >=100%)	341%	314%	332%	326%
Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа	1.82%	2.02%	1.32%	1%
төлбөрийн чадварын зохистой харьцаа	I түвшин	I түвшин	I түвшин	I түвшин



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



- Зудын эрсдэлтэй аймгуудад байгалийн гамшгийн үр дагаврыг бууруулах зорилгоор том малын хорогдол ихтэй Баянхонгор, Сүхбаатар, Төв аймгуудад 50 тонн малын тэжээл, Баянхонгор аймагт 300 ширхэг амин тун багц, Архангай аймгийн Цэцэрлэг, Батцэнгэл, Хотонт, Төв аймгийн ЗДТГ, Баянхонгор аймгийн Галуут, Баацагаан, Заг, Баянбулаг, Увс аймгийн Баруунтуруун, Өвөрхангай аймгийн Баянгол сумдад зам гаргах, өвс тэжээл тээвэрлэхэд зориулж нийт 212.6 сая төгрөгийн тусламж олгосон.
- 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд хамт олноороо 50 ширхэг буйлс мод тарьсан.
- “Үндэсний давхар даатгал” ХК үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн хүрээнд “Миний мэддэг даатгал” гар зургийн уралдааныг улс орон даяар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 3 насны ангилалд зохион байгууллаа. Уралдаанд 50 гаруй бүтээл ирснээс бага анги ангилалд I байр Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1-р сургуулийн 5в ангийн сурагч Болдбаатарын Нарангэрэл, II байр Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 1-р сургуулийн 4а ангийн сурагч Лхагвадоржийн Хурцэцэг, III байр Хан-Уул дүүргийн 115-р сургуулийн 5е ангийн сурагч Золбаярын Энхлэн, дунд анги ангилалд I байр Сүхбаатар дүүргийн 9-р сургуулийн 6г ангийн сурагч Өлзийбаярын Болорцэцэг, II байр Дархан-Уул аймгийн “Оюуны ирээдүй” сургуулийн 7 ангийн сурагч Батмөнхийн Аялгуу, III байр Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч Балтулгын Анхжаргал, ахлах анги ангилалд I байр Дархан-Уул аймгийн Дархан сумын “Од” сургуулийн 11 ангийн сурагч Лхагвасүрэнгийн Дөлгөөн, II байр Дархан-Уул аймгийн Дархан сумын “Од” сургуулийн 11 ангийн сурагч Баярсайханы Есүгэн, III байр Булган аймгийн Хутаг-Өндөр сумын ЕБС-ийн 10б ангийн сурагч Эрдэнэ-Очирын Билэгт нар тус тус шалгарсан. Эдгээр хүүхдүүдийн зургийг жаазлан мини үзэсгэлэн болгож, 10 жилийн ойд зориулсан “Эрсдэлд тэсвэртэй-Монгол улс” олон улсын форумын үеэр олон нийтэд танилцууллаа. Гар зургийн уралдаанд шалгарсан сурагчдыг өргөмжлөл, гарын бэлэг, мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшуулав.





I байр
Лхагвасүрэнгийн Дөлгөөн
Дархан-Уул аймгийн Дархан сумын "Од"
сургуулийн 11 ангийн сурагч /ахлах анги/



I байр
Өлзийбаярын Болорцэцэг
Сүхбаатар дүүргийн 9-р сургуулийн 6г
ангийн сурагч /дунд анги/



I байр
Болдбаатарын Нарангэрэл
Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1-р
сургуулийн 5в ангийн сурагч /бага анги/



ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Үндэсний давхар даатгал ХК (цаашид “Компани” гэх)—ийн 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)–уудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул “Үндэсний давхар даатгал” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2024 оны 02 дугаар сарын 5-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидны үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын Аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК



Монгол Улс, Улаанбаатар хот
2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Nexia International-ийн албан ёсны гишүүн
Веб: www.nexia.com

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	(Дахин тайлагнасан*)	
	2024-12-31	2023-12-31
Даатгалын орлого	7,386,567	5,754,807
Даатгалын үйлчилгээний зардал	(14,423,528)	(6,907,779)
Даатгалын үйлчилгээний үр дүн	(7,036,961)	(1,152,972)
Давхар даатгалын хураамжийн төлөлт	(3,102,413)	(2,231,308)
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр	8,646,645	3,891,536
Давхар даатгалын цэвэр үр дүн	5,544,232	1,660,228
Даатгалын үйлчилгээний цэвэр үр дүн	(1,492,730)	507,256
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	8,530,702	7,454,479
Цэвэр хөрөнгө оруулалтын орлого	7,037,973	7,961,735
Бусад олз / (гарз)	202,044	139,033
Ерөнхий ба удирдлагын зардал	(4,556,665)	(4,346,688)
Бусад үйл ажиллагааны зардал	(705,969)	(211,384)
Бусад санхүүгийн зардал	(587)	(19,042)
Татварын өмнөх ашиг	1,976,796	3,523,654
Орлогын албан татварын зардал	(845,071)	(740,760)
Тайлант жилийн цэвэр ашиг	1,131,725	2,782,894
Бусад дэлгэрэнгүй орлого / (алдагдал)	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	1,131,725	2,782,894

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 -НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН САНХҮҮ
БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	(Дахин тайлагнасан*)	
	2024-12-31	2023-12-31
ХӨРӨНГӨ		
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	1,630,703	1,483,751
Санхүүгийн хөрөнгө:	57,967,999	60,034,259
Хорогдуулсан хөрөнгөөр бүртгэх	57,967,999	60,034,259
Даатгалын гэрээний хөрөнгө	1,172,682	971,770
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	-	1,773,158
Авлага	389	25,712
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө	123,969	81,545
Бараа материал	18,882	6,415
Үндсэн хөрөнгө	201,788	170,294
Биет бус хөрөнгө	5,054	254,087
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	44,524
Нийт хөрөнгө	61,121,466	64,845,516
ӨР ТӨЛБӨР		
Даатгалын гэрээний өр төлбөр	11,714,441	13,896,514
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	-	-
Дансны ба бусад өр төлбөр	27,977	1,010,967
Богино хугацаат түрээсийн төлбөр	-	50,173
Орлогын албан татварын өр төлбөр	410,871	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	20,893	15,913
Нийт өр төлбөр	12,174,182	14,973,567

ЭЗДИЙН ӨМЧ		
Хувьцаат капитал	24,500,000	24,500,000
Алдагдлаас хамгаалах сан	19,000,000	19,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	4,186,962	489,264
Хуримтлагдсан ашиг	1,260,322	5,882,685
Нийт эздийн өмч	48,947,284	49,871,949
Нийт өр төлбөр ба эздийн өмч	61,121,466	64,845,516



☎ 7577-0002

✉ info@mongolianre.com

🌐 <http://mongolianre.com/>



📘 <http://facebook.com/mongolianre>

📷 <http://instagramm.com/mongolianreinsurance>

📺 <http://youtube.com/@mongolianre6433>

🌐 <http://linkedin.com/company/mongolian-re>

🐦 http://twitter.com/Mongolian_Re

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАРДААТГАЛ